



Монгол Улсын Ерөнхийлөгчийн
Тамгын газар

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН САНААЧИЛГААР



**“ТОМ ТӨРӨӨС УХААЛАГ ТӨР ЛҮҮ”
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛДӨХ УУЛЗАЛТ**

*Монгол Улсын Ерөнхийлөгч
Цахиагийн ЭЛБЭГДОРЖ-ийн
хийсэн танилцуулга*

Төрийн ордон
2013 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр

“ТОМ ТӨРӨӨС УХААЛАГ ТӨР ЛҮҮ”
Үндэсний зөвлөлдөх уулзалтын хөтөлбөр
2013 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр

13:00 – 13:45 Оролцогчдын бүртгэл

14:00 – 14:05 Оролцогчдыг танилцуулах

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга П.Цагаан

14:05 – 14:50 Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн ЭЛБЭГДОРЖ Үндэсний зөвлөлдөх уулзалтыг нээж үг хэлнэ

14:50 – 16:40 Салбар хуралдаан

- **Шийдвэр гаргагчдын төлөөлөл оролцсон салбар хуралдаан**

Хөтлөгч: Монгол Улсын Их Хурлын дарга Зандаахүгийн ЭНХБОЛД,

Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд

- **Бизнес эрхлэгчдийн төлөөлөл оролцсон салбар хуралдаан**

Хөтлөгч: Монгол Улсын Ерөнхий Сайд Норовын АЛТАНХУЯГ,

Улсын Их Хурлын гишүүн С.Дэмбэрэл

- **Орон нутгийн удирдлагуудын төлөөлөл оролцсон салбар хуралдаан**

Хөтлөгч: Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захиргач Э.Бат-Үүл,

Сүхбаатар аймгийн Засаг дарга Ж.Батсуурь

- **Хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөл оролцсон салбар хуралдаан**

Хөтлөгч: Улсын Их Хурлын гишүүн Ч.Сайханбилэг,

Монголын Сэтгүүлчдийн Эвлэлийн ерөнхийлөгч Б.Галаарид

- **Эрдэмтэн, судлаачид олон нийтийн байгууллагын төлөөлөл оролцсон салбар хуралдаан**

Хөтлөгч: Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга П.Цагаан,

Монгол Улсын Их Сургуулийн захирал А.Галтбаяр

16:40 – 17:00 Цайны завсарлага

17:00 – 18:15 Нэгдсэн хуралдаан

/Салбар хуралдаанаас гаргасан санал, зөвлөмжийг хөтлөгчид танилцуулна/

- Шийдвэр гаргагчдын төлөөлөл оролцсон салбар хуралдаан
- Бизнес эрхлэгчдийн төлөөлөл оролцсон салбар хуралдаан
- Орон нутгийн удирдлагуудын төлөөлөл оролцсон салбар хуралдаан
- Хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөл оролцсон салбар хуралдаан
- Эрдэмтэн, судлаачид олон нийтийн байгууллагын төлөөлөл оролцсон салбар хуралдаан

18:15 – 19:00 Санал хураалт /Зарим асуудлаар/

Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн ЭЛБЭГДОРЖ Үндэсний зөвлөлдөх уулзалтыг хааж үг хэлнэ.

Нээлт болон нэгдсэн хуралдааныг МҮОНРТ, Ийгл телевизээр шууд дамжуулна. Жич: Салбар хуралдаан хаалттай болно.

Эхлэл

- Үдээс хойш эхэлж байна. Би Монголын төрд байнга өглөө байгаасай гэж боддог. Иймээс өнөөдрийн “Том төрөөс ухаалаг төр лүү” гэдэг Үндэсний зөвлөлдөх уулзалтыг хийж байна.
- Энэ уулзалтад шийдвэр гаргагчид, бизнесийн төлөөлөл, орон нутаг, хэвлэл мэдээлэл, судлаачид, олон нийтийн байгууллагын бүрэлдэхүүн оролцож байна.
- Ажлын хэсэг байгуулсан – судлаачид, нам , ОНБ-ын төлөөлөл иргэдэд талархаж байна.

Зорилго:

- Өнөөдрийн ярих асуудал бол бидний дундын зовлон. Энэ бол ганцхан төр, ЗГ, хэн нэгний хувийн зовлон биш, энэ бол Монголын зовлон.
- Биднийг, бүгдийг нийлүүлээд Монгол Улс, Монголын төр гэж хардаг.
- Монголын төлөө ямар учраас Монгол хүн бур санаа зовдог юм бэ? Төрийн тухай яагаад хүн бүр, хөгшин залуугүй ярьдаг вэ? Тэр хүн чинь Монголын нэг эс , төрийн нэг эс учраас. Хүн бүхэн улсдаа, төрдөө хувьцаатай, миний оролцоо энд бий гэж хардаг. Ийм учраас бид өргөн бүрэлдэхүүнээрээ энэ зөвлөлдөх уулзалтыг хийж байна.

Нэг: Монгол – бусадтай харьцуулж үзвэл.

Эхлээд бид бусадтай өөрийгөө харьцуулж харья.

Өрсөлдөх чадварынхаа түвшингээр бид ямар байдалтай байна вэ?

Өрсөлдөх чадварын хэмжүүр




Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв нь Дэлхийн өрсөлдөх чадварын төвтэй хамтарч жил бүр Монголын өрсөлдөх чадварын тайланг гаргадаг.

Өрсөлдөх чадварыг хэмжих аргачлал




Эдийн засаг



Дундаж:
56

Засаглал



7

0-100, оноо

Бизнесийн орчин



Дэд бүтэц



0-100, оноо

8

Нэг хүнд ногдох ДНБ



Худалдан авах чадвараар, ам. доллар

Эдийн засгийн төрөлжилт



Орлогын цөөн/олон эх үүсвэр, 0-10 оноо ⁹

Дотоодын нийт хуримтлал



Тэрбум ам. доллар (Дэлхийн Банк, ОУВС)

Жилд нэг хүнд ногдох хуримтлал



ам. доллар (Дэлхийн Банк, ОУВС)

Улсын зээлжих чадвар



Зээлжих үнэлгээ (Institutional Investor), 0-100
оноо

Гадаад валютын нөөц



Дундаж:
66

Дундаж:
\$115 тэрбум

Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ



Дундаж:
\$286 тэрбум

Тэрбум ам. доллар

Хувьцаагаар орж ирсэн шууд хөрөнгө оруулалт



Дундаж:
\$137 тэрбум


Тэрбум ам. доллар

Төрийн бодлого, шийдвэрийн хэрэгжилт




Хэрэгжилт нь үр дун
муутай/сайтай, оноо 0-10

Төрийн өмчтэй аж ахуйн нэгжүүд



Төрийн өмчтэй аж ахуйн нэгжүүд бизнесийн үйл
ажиллагаанд муугаар **нөлөөлдөг**, 0-10 оноо

Хүний нөөцийн чанар



Мэргэшсэн ажиллах хүчийг олж
ажиллуулахад **бэрхшээлтэй**, 0-10 оноо

Технологийн хөгжил



Дундаж:
5

Дундаж:
6

Хууль эрх зүйн орчин нь технологийн
хөгжлийг **чөдөрлөж** байна, 0-10 оноо

Эрчим хүчиний дэд бүтэц



Эрчим хүчиний дэд бүтцийн хүрэлцээ ба үр ашиг
хангалтгүй/хангалттай, 0-10 онoo

Агаарын тээвэр



Тэргүүлэх авиа компаниудын тээвэрлэсэн
зорчигчдын тоо, мянга


**Төрөөс боловсролд зарцуулсан,
нэг хүнд ногдох зардал**



**Дундаж:
\$655**

Нэг хүнд ногдох ам. доллар

**Сурагч-багшийн харьцаа
(бага, дунд)**




**Дундаж:
19**

Нэг багшид ногдох сурагчийн тоо

16

Бизнесийн орчны судалгаа:

Дэлхийн Банк (2013)




Хоёр: Бидэнд ямар боломж байна вэ?


1990-2050

Хэмжүүр / Он	1990	2000	2013	2020	2030	2040	2050
Монгол Хүн - “Олуулаа” (сая)	2	2.4	2.9	3.5	4.5	5.5	7
Дундаж наслалт (жил)	60	64	68	73	78	80	85
ДНБ (тэрбум \$)	2.7	1.1	11	40	60	150	380
1 хүнд ногдох ДНБ (\$)	1,290	470	4,000	11,500	13,000	27,000	55,000
Дотоодын хуримтлал (тэрбум \$)	0.09	0.08	3.4	15	28	40	50
Хөрөнгө оруулалтын зэрэглэл (S&P)	-	-	BB-	A	AA	AAA	AAA
Хуулийн засаглал (Transparency International)	-	-	94	20	10	5	1
Өрсөлдөх чадвар (World Economic Forum)	-	-	98	50	25	10	1

Хүн амын өсөлт




Дундаж наслалт




ДНБ өсөлт

Тэрбум \$ ам. доллар




Нэг хүнд ногдох ДНБ өсөлт

\$ ам. доллар




Хөрөнгө оруулалтын зэрэглэл



Монголын хөгжлийн зорилт

Хүн ам 7 сая




Гурав: ЗОРИЛГО. Үндэсний зөвлөлдөх уулзалт

Зорилго: 1. Эдийн засгаа яаж өсгөх вэ?
2. Төрөө яаж засах вэ?

Энэ зорилго тодорхой болохгүй бол төрд итгэх итгэл нэмэгдэхгүй.

Ямар учраас төрд итгэх итгэл буурдаг вэ? Манай төрийн ажлаас л болж байна.



... бидний ажил ийм л байна.

- Ийм учраас одоо бид зогсох хэрэгтэй байна. Цуглаж ярилцаж, зөвлөлдөх хэрэгтэй байна. 24 жил бид дураараа хурдаллаа. Одоо мориноосоо буугаад ярилцах цаг болсон. Мориор бол морио сэлгэх, онгоцоор бол эзлж хийх цаг болжээ.
- Зогсох дохио - дуут дохио дуугараад удсан байна. Манай нийгэм нээлттэй учир шуугиан ихтэй. Гэхдээ дуугарч байгаа дохиог сонсох хэрэгтэй, зогсох хэрэгтэй. Юу болж байгааг ойлгох хэрэгтэй.

Зарим тоон үзүүлэлт

- ❖ Өнгөрсөн нэг жил гаруйн хугацаа **1.5** тэрбум доллар буюу **2.5** ихнаяд төгрөгийн хохиролтой өнгөрлөө.
- ❖ Улсын төвлөрсөн төсвийн орлого 2013 онд **1-1.5** ихнаяд төгрөгөөр тасрахаар байна.
- ❖ Хүний хөгжлийн санд **1** ихнаяд төгрөгийн өр үүслээ.
- ❖ ДНБ-д эзлэх ЗГ-ийн өр **8.4** ихнаяд буюу **49.5%** (Австрали **24%**, Чили **10%**)
- ❖ 2013 оны гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээг 2011 оны түвшинд (ОТ-г оруулалгүйгээр) хүргэхэд **2** дахин өсгөх хэрэгтэй байна.
- ❖ Монгол Улсын ДНБ-ий хэмжээ өнөөдрийн байдлаар **17** ихнаяд ₮ буюу **10** тэрбум доллар.

Зарим тоон үзүүлэлт

- ❖ ДНБ дэх төсвийн зардал 2014 онд төлөвлөснөөр 7.3 ихаяд буюу 41.1% болж байна.
- ❖ Дээр нь Чингис Бондын 1.5, ХБанкны 600 сая \$, төгрөгөөр бол 3.5 ихаяд буюу нийтдээ 10.8 ихаяд. Энэ нь ДНБ-д эзлэх төсвийн зардал 63.5% болно гэсэн үг.
- Хөрөнгө оруулалт багасахаар үйлдвэр үйлчилгээ багасч байна. Үйлдвэр үйлчилгээ багасахаар орлого тасарч байна. Орлого тасрахаар амьдралын өртөг нэмэгдэж байна. Төрд түүнийг нөхөн боломж алга.
 - Жирийн иргэнд, амьдралаа авч яваа хүмүүст хамгийн хэцүү тусч байна. Бүгд өрөнд орж байна. Ажил бизнесийнх нь баталгаа алдагдаж байна.
 - Өнгөрсөн 1 жил гаруйн хохирлыг би 2.5 ихаяд гэж хэлсэн. Энэ бол манай ард түмний төлж байгаа төлбөр. Үүнийг өлгийтэй хүүхэд, өтгөс бууралдаа хуваавал хүн нэг бүр 863 мянган төгрөгөөр хохирчээ. Энэ бол Монгол Банкны статистик шүү.
 - Би үүнийг нэг үгээр “Популизмын өртөг” гэж нэрлэж байгаа.

“Хашгирахыг нь популистууд хийдэг, төлбөрийг нь ард түмэн төлдөг”

АСУУЛГА

❖ Монгол Улсын төр том төр мөн үү?

- Мөн
- Биш
- Мэдэхгүй

❖ Монгол Улсын төр ухаалаг төр мөн үү?

- Мөн
- Биш
- Мэдэхгүй

❖ ДНБ-д эзлэх төрийн зардал:

- 30 хүртэл = хэвийн
- 30-аас дээш = хэвийн бус
- 40-өөс дээш = үрэлгэн, их зардалтай, том...

Төр томорч буй шалтгаан

1. **Төрд мэдлэг, технологийн дэвшил орж ирэхгүй байна** (бүтэц, орон тооны механик ёсөлтөөр л асуудлыг шийдэх гэж оролдож байна)
2. **Төрд ажиллах ашигтай байна** (лиценз, зөвшөөрөл олгох, бизнес аж ахуйд оролцох, дураараа хэм хэмжээ тогтоо замаар)
 - Төрд шударга ажиллаж буй хүн олон бий. Тэр бүү хэл сайд дарга нарын дунд ч бий.
 - Лиценз, зөвшөөрөл = 1164 гэж тоологдсон (Тоолоод ирэхээр хонийг ямаа, бодыг бог гээд нэрлэчих тохиолдол гарч байна)
 - Төрөөс завших олон арга байна. Жижиг боловч нэг ноцтой зүйл ажиглагдаж байгаа нь Зөвлөх нэрээр хүн ажиллуулж, тэр хүнээрээ хууль бус муу бүхнийг хийлгэх байдал хавтгайрч байна.
 - Зөвлөх нь ашиг сонирхлын зөрчилгүй бол яая гэхэв. Найзыгаа, компанийн захирлаа, гэр бүлийнхээсээ авах юм. Өнөөдөр манан сайд нар дэргэдээ 24 зөвлөх ажилуулж байна. Зөвлөхгүй ч сайд бий. 3-4 зөвлөхтэй ч сайд бий. Засаг дарга наарт л гэхэд 15 зөвлөх байна.
 - Зарим зөвлөх бол яамны аранга болсон байна. Зарим зөвлөх бол териин аранга болсон байна.
 - Териин байгууллагыг аж ахуйн ч биш, териин ч биш болгож байна. Нэг л олон аж ахуй, сан, товчоо, төсөл, хөтөлбөр хариуцсан хүмүүс.
 - “Улсыг компани болгож болохгүй” гэж нэг Нобелийн шагналтан хүртэл хэлсэн байна лээ.
 - Зарим газар захирал нь томилогодохоос өмнө шахах бараа нь очихсон байна гэж сонсогдох юм. Зарим томилгооны шалгуруу сайдын бизнесийг хэр дэмжихэд оршиж байна.
 - Төр нь баялаг руу дайрдаг улсад иргэд нь ядуу л байх болно. Төр өрмийг нь авдаг, иргэд нь хусмыг нь хамдаг байж болохгүй. Эдийн засаг ёсөөд байгаа ч иргэд нь ядуураад байгаагийн нууц бол тэр ёсөлтийг төр булааж авч буйд оршино.
3. **Териийн үйл ажиллагаанд харилцан уялдаа, нэгдмэл байдал алга** (Иймээс төр түймэр унтраагч, сайд дарга нар нь хамхлагийн эзэд, бие даасан хангигууд шиг загнаж байна)
 - Сайд дарга нар ажлаа эрх мэдэл, эрх ямба гэж ойлгодог нь буруу. БХ-ын сайд бол БХ бодлого л хариуцсан хүн, эрчим хүчиний сайд бол цахилгаан дулаан л хариуцсан хүн. Хариуцсан ажлаа л нийт систем дотор хийх үүрэгтэй. Хөгжмөөр бол найрал хөгжим доторх нэг л хөгжмийн зэмсэг эзэмшигч шүү дээ. Лимбэ үлээдэг хүн хийл тоглоод байдаггүйтэй адил. Лимбээ л үлээх ёстай.

“Төр нь баялаг руу дайрдаг улсад иргэд нь ядуу л байх болно. Төр өрмийг нь авдаг, иргэд нь хусмыг нь хамдаг байж болохгүй. Эдийн засаг ёсөөд байгаа ч иргэд нь ядуураад байгаагийн нууц бол тэр ёсөлтийг төр булааж авч буйд оршино”

Та төртэй харьцдаг уу?

- ❖ Харьцдаггүй 60 %
- ❖ Хааяа харьцдаг 30 %
- ❖ Үргэлж харьцдаг 8 %

Ажил хэрэгч хүмүүс төрөөс юу хүсэж байна вэ?

- ❖ Бүү саад бол 42 %
- ❖ Тогтвортой байдал 34 %
- ❖ Тусламж дэмжлэг 21 %

Бизнес эрхлэгчид юу хүсэж байна?

1. **Эрх зүйн орчин** (тогтвортой, тэгш, тунгалаг)
 2. **Татварын орчин** (өрсөлдөхүйц, зохистой, төлөвлөж болохуйц)
 3. **Төр** (бизнест оролцдоггүй, хэрэгтэй үед тусладаг, сонирхлын зөрчилгүй – өрсөлддөггүй)
- **Өнөөдрийн дарлагдсан ард бол бизнес эрхлэгчид.** Бизнес эрхлэгчдийг дарамталдаг бүхэл бүтэн тогтолцоо байна. Байцаагч очино, араас нь шахаа очино. Аягүй бол хуулийнхан очно. Бүр тэгж явж байхдаа зарим этгээдүүд төрийн нэр барина, хүний нэр барина. Үүнийг зогсоох цаг болсон.

“Өнөөдрийн дарлагдсан ард бол бизнес эрхлэгчид”

Төрд байгаа буруугийн жагсаалт

1. “Төр бүхэнд оролцож, бүхнийг шийдэх ёстай”
 2. “Хууль хариуцлага яахав, аргалж болно”
 3. “Албан тушаалд очсон бол хүссэнээ гүйцэлдүүлж болно”
 4. “Туршлага байхад судалгаа, онол хэрэггүй”
 5. “Сонгуулийн хөтөлбөр сонгогчдод л таалагдахад хэрэгтэй”
 6. “Төр өмч эзэмшиж, аж ахуй эрхлэхгүй бол бусад нь завшина”
 7. “Шийдвэр гарч, өдөр өнгөрч байвал маргааш яахав”...
- Улс төрчид, сонгуулийн үед сонгогчдоо боддог бусад үед өөрийгөө боддог байж таарахгүй.
 - Таны төлөө бүхнийг хийх гэж оролддог төр бол танаас бүхнийг салгаж авч дуусдаг.

“Улс төрчид, сонгуулийн үед сонгогчдоо боддог
бусад үед өөрийгөө боддог байж таарахгүй”
“Таны төлөө бүхнийг хийх гэж оролддог төр бол
танаас бүхнийг салгаж авч дуусдаг”

Дөрөв: Ухаалаг төрийн тухай

Монгол Улс ямар замаар явах ёстой вэ?

- ❖ Хуулийн засаглал
- ❖ Ухаалаг төр
- ❖ Нээлттэй, оролцоотой, аюулгүй нийгэм

Нээлттэй ардчилсан төр юу хийдэг вэ?

- ❖ Аюулгүй байдлыг хангах
- ❖ Иргэнд үйлчлэх
- ❖ Хууль хэрэгжүүлэх

Ухаалаг төрд шилжих шаардлага

- ❖ Хүмүүнлэг, ардчилсан, иргэний нийгэм байгуулах зорилгод нийцнэ.
 - ❖ Орчин нөхцөл, хандлага өөрчлөгдөж байна.
 - ❖ Төрөө байгуулсан олон нийт төрийг ухаалаг байхыг шаардаж байна.
-
- Шинэ зуун гарлаа. Өмнөх зууны юм одоо хоцрогдож эхэллээ.
 - 2005 онд 8 жилийн өмнө бид “Цахим Монгол” гээд эхэлж байсан. Одоо бид ухаалаг монгол, ухаалаг төрийн тухай ярих цаг боллоо.
 - Энэ байдал Монголын ч биш нийтийн хандлага болж байна. НҮБ-аас хүртэл Ухаалаг төрийн үзүүлэлт (Smart government index) гэж гаргаж байна.
 - Ye солигдлоо. 1989, 90 онд төрж байсан охид, хөвгүүд гэр бүл болж байна. Бид чинь шинэ айлд шинэ гэр бэлдэж өгдөг уламжлалтай. Төрөө шинэчилж өгье.

Ухаалаг төрийг яаж таних вэ?

- ❖ Орон зай, цаг хугацаа харгалзалгүй үйлчилгээ авч болдог.
- ❖ Хууль журам нь цэгцтэй, үйл ажиллагаа нь стандарттай, мэдээллийн нэгдсэн сантай.
- ❖ Иргэдээ чадвартай, ёс зүйтэй, бүтээлч, санаачилгатай болоход нь дэмжлэг үзүүлдэг.
- ❖ Асуудал гарах, эрэлт үүсэхэд хамгийн оновчтой шийдэл гаргах чадавхтай.
- ❖ Хийх ажлаа хамгийн үр дүнтэй аргаар гүйцэтгэдэг.

Зургаар таньж болно. Ухаалаг төрийн ажлын байр бол удирдлагын төв шиг л харгадаг. Цахилгаан станцын хянах самбар, орчин үеийн эмнэлгийн үйлчилгээ Сансырын төвийн удирдлага шиг л болсон байна. Манай нийслэлийнхэн ажлын байрныхаа зургийг MobiCom-оор хийлгэж байгаа гэж сонссон.

Нийслэл нэгдсэн сүлжээтэй болж байна гэсэн үг. Энэ нэгдсэн сүлжээ гэдгийн ард ерөөсөө хэмнэлт яригдаад байгаа юм. Нэгдсэн сүлжээнд ороод ирэхээр ямар олон ажил үйлчилгээг төрийн байгууллагууд давхардуулан эрхэлж байснаа мэдэх болно.

Ер нь улс орнууд, хотууд Cloud-Үүл систем хэрэглээд эхэлчихсэн байна. Манай Улаанбаатарынхан бол Бат-Үүлтэй, Монгол бол Пан-Үүлтэй болно гэсэн үг. Пан гэдэг чинь нэгдсэн гэсэн үг шүү дээ.

ХХ зууны эхээр үйлдвэрлэлд конвейрийн систем нэвтэрсэн. Ямар их дэвшил, ашиг авчирсныг Та бүхэн мэднэ. Үйлдвэржилт, үйлчилгээ хүчээ авсан.

Ухаалаг төрийн зорилт

- ❖ Хамгийн ухаалаг засаглал.
- ❖ Хамгийн аюулгүй нийгэм.
- ❖ Хамгийн үр дүнтэй үйлчилгээ.

Төрийн амжилтад хүрэх жор янз бүр байдаг байх.

Миний бодлоор ухаалаг төрийн амжилтын жор бол хүний сайхан амьдрах хүсэлд үйлчлэхэд оршино.

- Ухаалаг төр бол цаасны төр. (судалгаа, шийдвэр, хууль журам)
- Ухаалаг төр бол технологийн дэвшил ашигладаг төр. (Сүлжээ, хянах самбар, мэргэжилтэн)
- Ухаалаг төр бол чадвартай хүн ажилладаг төр.

Би энд харь юм ярьж байгаа юм биш, Монголын төр ухаалаг, хуулттай, чадавхтай байсан.

Бид чинь дэлхийд анх удаа морин өртөө, шуудан, мэдээлэл холбооны шуурхай харилцааг нэвтрүүлсэн улс. Өмнө хийж байсан ажлаа одоогийн төрдөө нэвтрүүлэх л гэж ярьж байна.

- Ухаалаг төр = гэдэг бол таныг байгаагасаа, боломжоосоо илүү ухаантай бол гэсэн үг биш. Технологийн дэвшил ашигла. Ажлаа илүү үр дүнтэй, хүртээмжтэй хий гэсэн үг.

“Ухаалаг төр бол чадвартай хүн, технологийн дэвшил, судалгаа, хууль журмын цогц юм”

Ухаалаг төрийн шийдвэр гаргах шатлал

- 1. Ахан шат ба мониторингийн түвшин:**
(Мэдээлэл, статистик, санал)
- 2. Дунд шат ба анализын түвшин:**
(Тайлан, судалгаа, төлөвлөлт)
- 3. Дээд шат ба синтезийн түвшин**
(шийдлийн хувилбар, төсөөлөл, шийдвэр)
 - Яагаад би “Ухаалаг” гэж яриад байна вэ! Ухаалаг хүн ёс зүйтэй байдаг. Ухаалаг төр хариуцлагатай байдаг.
 - Ухаалаг байж, ёс зүйтэй байж, хариуцлагатай байж бусдад хүндлэгддэг.

“Ухаалаг хүн ёс зүйтэй байдаг.
Ухаалаг төр хариуцлагатай байдаг”

Ухаалаг төрийн бодлого, үйл ажиллагааны үндсэн зарчим

- ❖ Хуулийн засаглал, нээлттэй байдал, иргэдийн оролцоо.
- ❖ Төрийн байгууллага, иргэд, орон нутгийн хамтын ажиллагаа.
- ❖ Өрх бүрт хүрсэн, тогтвортой өсөлтийг дэмжих бодлого.
 - Inclusive economic growth (Эдийн засгийн оролцоотой өсөлт) = Өрх бүрт, хүн бүрт өгөөж нь хүртдэг
- ❖ Нэгдсэн мэдээллийн сан, судалгаа, үйлчилгээ.
- Ухаалаг төр бол З цагийн хэлхээн дээр оршдог. Өнгөрснөөс сайныг нь авдаг, өнөөдрийн шаардлагыг хангасан, ирээдүйгээ тооцсон төр юм.

“Ухаалаг төрийг гар зураг, гарын үсэг ашиглаж бий болгохгүй. Алдаанаасаа суралцаж, технологийн дэвшил, ухаантай иргэдээ түшиж бий болгоно”

Ухаалаг төрийн бүтэц

- ❖ Хуулийн хэрэгжилтийг хангах хэсэг
- ❖ Судалгаа, хөгжлийн хэсэг
- ❖ Үйлчилгээ хүргэх хэсэг
- ❖ Үйл ажиллагааг дэмжих хэсэг (Гэрээ, түрээс)
- Төр юуг түрээс, гэрээгээр хэрэглэж болох вэ !!
 - Эд хогшил, компьютер, машин, байр, цэвэрлэгээ, хool хүнс...
 - Төр байр, машин түрээслэнэ гэхэд байр, машин өөрөө ороод ирнэ = “Төр цамхаг” дордоо босно
 - Хар байшин : Хотын захирагааны. Хувийнханд (ганцхан нөхцөлтэй) түрээслүүлнэ гээд дуудлага худалдаагаар зарчих. Бүх агентлаг орчихно.
 - Хэвлэх үйлдвэр : Энэ балгасны оронд яамдын байшин барьчих. Засаг түрээслэх нөхцөлтэй хувийнхнаар яамдын байшин барьчих (БХЯ, ГХЯ-наас бусад бүх яамд орж болно) Ингэж Засаг байраа түрээслэдэг байх юм бол Засаг түрээсний зовлонг иргэдтэй адил шууд мэдэрнэ. Засаг эргээд хямгач болж, үрэлгэн байдлаасаа сална. Түрээс нээгдэх тусам Засаг нэг бол төсвөө нэмнэ, нэг бол байраа багасгана.
 - Түрээс, гэрээний сайн тал
 - (цалин, даатгал, зардал. Цаад талдаа. Татвар төлөгчдийн мөнгө зарахгүй)

“Шинэ бүтцэд шилжихэд хэн эсэргүүцэх вэ? Хуучнаас ашиг хийгчид л эсэргүүцэнэ.
Бид шилжих л болно. Монгол Улс ухаалаг төртэй болно”

Тав: Шийдэх цаг ирлээ

ХАНГАЛТТАЙ !

*(Хурал, ярилцлага, судалгаа, хэлэлциүүлэс,
цаас, бухимдал...)*

Юу дутагдаж байна вэ?

- ❖ Үйлдэл
- ❖ Шийдвэр
- ❖ Гүйцэтгэл

ХУУЛЬ

Лиценз зөвшөөрлийн тухай

- ❖ Шинээр лиценз зөвшөөрөл бий болгохыг хориглох,
- ❖ Лиценз зөвшөөрлийг зөвхөн хуулиар бий болгох,
- ❖ Лиценз зөвшөөрлийн бүртгэл хийж нийтэд зарлах,
- ❖ Лиценз зөвшөөрлийг ялгах, хүчингүй болгох, шилжүүлэх,
- ❖ УИХ-аас хууль, лиценз зөвшөөрлийн нэгдсэн жагсаалтыг батлах (Улс, олон нийтийн аюулгүй байдалтай холбоотой)
- ❖ Тийм, 2004 оны намар би урж байсан. Төрд, албан тушаалтанд лиценз зөвшөөрөл ашиг авчирч л байгаа бол бий болсоор л байх болно. Ийм учраас ургамалыг нь биш хөрсийг нь солих хэрэгтэй. Зарим тохиолдолд хөрс ч үгүй болгох, бетондох хэрэгтэй.
- Шилжүүлж болох лицензийг лиценз олгогчтой нь шилжүүлж болно . Тэд ААН байгуулаад л тэр ажлаа хийг. 1-3 жилийн давуу эрх олгож болно. Тэд чинь өглөө босоод зангия зүүгээд сурчихсан хүмүүс .
- Өнөөдөр энэ талаар ажил хийж байгаа ч хэрэгжилт сул, хууль зөрчигч хариуцлага хүлээхгүй байна. Хууль 2 юм нэхэхэд = газар дээрээ 20 юм нэхсээр байна.
- Хууль бол – замын хөдөлгөөний дүрэм = хуулиас давсан дүрэм зохиож болохгүй. Хуулийг хэрхэн сайн биелүүлэх дүрэмтэй бай.

Үндсэн санаа

ХУУЛЬ

Төрийн аж ахуйн үйл ажиллагааг хязгаарлах тухай

- ❖ Шинээр төрийн өмчит үйлдвэр, аж ахуй нэгж байгуулахыг хориглох,
- ❖ Төрийн өмчит үйлдвэр ААН-ийг зөвхөн хуулиар байгуулах,
- ❖ Төрийн өмчит ААН-ийн ТУЗ-ийг төрийн албанаас тусгаарлаж, компанийн удирдлагын шилдэг загварыг ашиглах,
- ❖ Нэмэлт хувьцаа гаргах, хөрөнгө оруулалт татах хэлбэрийг түлхүү ашиглах,
- ❖ Ашгийн шалгуур тавих, нэмэлт хувьцаа гаргах, хөрөнгө оруулалт татах хэлбэрийг ашиглах
- ❖ Тайланг УИХ, ЗГ-ын хуралдаанаар жил бүр хэлэлцэх,
- ❖ Төрийн өмчийн хорооны бүтцийг олон улсын жишиг стандартад нийцүүлэх.
- Төрийн өмчит ААН 101 гэж гарсан, 47.653 хүн ажиллаж байгаа.
- Ухаалаг Төр бол аж ахуй эрхлэгч төр биш = Эрдэнэс ТТ бол хуулийн, цаасны, мэргэжлийн компани л байх ёстой, нүүрс зөөгч биш.

“Ухаалаг төр бол манлайлаж, үйлчлэгч, гэрээлэгч төр юм”
“Төр муугаас салъя гэвэл мөнгөнөөс, аж ахуйгаас эхлээд сал”

ХУУЛЬ

Шилэн дансны тухай

- ❖ Төрийн бүх байгууллага, төрийн өмчит үйлдвэр, аж ахуй нэгжид хамаарна,
- ❖ **Нэг сая** төгрөгөөс дээших төсөв, мөнгө, хөрөнгөний зарцуулалттай холбоотой бүх шийдвэрийг нээлттэй болгоно.
- ❖ Шийдвэр бүрийг 72 цагт багтаан албан ёсны цахим хуудаст байршуулж, олон нийтэд мэдэгдэнэ.
- ❖ Хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлээгүй албан тушаалтантай тооцох хариуцлагыг тодорхой заана.

*“Иргэд ихэнх газар төр, улстөрөөс залхсан байдал.
Харин тэд мөнгийг нь яаж зарж байгааг л сонирхдог”*

ХУУЛЬ

Төсвийн хөрөнгө оруулалтын тухай

- ❖ Хувийн хэвшлийн хийж болох хөрөнгө оруулалтыг төсвөөс хийхийг, төр өр тавьж хувь эзэмшихийг зогсоох.
- ❖ Төрөөс зайлшгүй хийх хөрөнгө оруулалтын жагсаалтыг батлах (цахилгаан дулааны шугам сүлжээ...)
- ❖ Бусад хөрөнгө оруулалтыг тогтсон томьёогоор тооцож ОНХСангаар дамжуулан иргэд, орон нутгийн мэдэлд өгөх.
- ❖ Хөрөнгө оруулалтаар хийсэн байгууламжийнхаа урсгал зардлыг хууль, гэрээнд өөрөөр заагаагүй бол хөрөнгө оруулалт хийсэн тал хариуцдаг байх.
- ❖ Төр зайлшгүй тохиолдолд хөрөнгө оруулалтаас хувь биш зөвхөн хувьцаа эзэмшдэг байх.

*“Төр хувь эзэмших хэрэггүй гэдгийг
Оюутолгойн 34% орой руу ортол ойлгууллаа”*

ХУУЛЬ

Төрийн бараа үйлчилгээ, худалдан авалтын (тендер) тухай

- ❖ Төсвийн мөнгийг зөвхөн дотоодод үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээнд зарцуулах.
- ❖ Эхнээсээ эцсээ хүртэл олон нийтэд нээлттэй, ил тод байх.
- ❖ Орон нутагт иргэдээр хэлэлцүүлж шийдвэрлүүлэх.
- ❖ Төрөөс ашгийн хэмжээ, бусад шалгуурыг зарлах.
- Бөөний зарчим чухал. Сумын 1 сургуулийг засах, барих гэвэл хэрэгтэй материалыг нь гаднаас зөөдөр. Харин аймгийн бүх сургуулийг засах, барих гэвэл үйлдвэр хэрэгтэй болно. Ингэж тендерээр дамжуулан Монголд хэрэгтэй үйлдвэрлэл хөгжинэ. Хүмүүс ажилтай, орлоготой болно.
- Та бүхэн барилга барихад гарч буй хандлагыг харж байгаа. ААН, Хүмүүс, зуурмагийг, дээврийг, засал чимэглэлийг, хаалга цонхыг, тавилгыг, цахилгааныг “манайх хийе” гэж ирээд чанараараа уралдаад хийчихэж байна.
- Ийм болчихвол Төр тендерчинээрээ, идээч уугаачаараа дуудуулж суух шаардлагагүй болно.

“Ард түмэн алдагдсан эрхээ л нэхэж байна.
Төрдөө, хийсэн бараа бүтээгдэхүүнээ төрдөө худалдах,
чадахаа хийх эрхийг надад өгөөч л гэж байна”

Үндсэн санаа

ХУУЛЬ

Монгол Улсын хөгжлийн зорилт, хэрэгжилт, хяналтын тухай

Энэ зорилт нь:

1. Хэмжих болохуйц
 2. Хүрч болохуйц
 3. Ойлгомжтой, оновчтой
- ❖ Териин бүх байгууллага, албан тушаалтан шийдвэр гаргахдаа мэдүүлэг бөглөдөг байх:
 1. Хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх,
 2. Монголын хөгжлийн зорилтод нийцэж байгаа эсэх,
 3. Үр өгөөжтэй эсэх (санхүү, эдийн засаг, нийгэм)
 - ❖ Сонгуульд оролцож байгаа нам, нэр дэвшигчид мөрийн хөтөлбөртөө МХЗ-ыг хэрхэн хангах тухай заалтыг заавал тусгадаг байх (аудит, сонгуулийн байгууллага хянах)
 - ❖ УИХ, Засгийн газар жилд нэгээс доошгүй удаа МХЗ-ын биелэлтийн явцыг хэлэлцдэг байх.
 - ❖ Таван жил тутам УИХ-аас МХЗ-д нэмэлт оруулах эсэхийг авч хэлэлцэх.

Мэдүүлэг гэдэг нь шийдвэр бүрийн ард шийдвэр гаргахдаа дээрх шалгууруудыг тооцож бөглөсөн хуудас юм. Шийдвэр бүрийн ард мэдүүлэг үлдэнэ. Тэр мэдүүлэг нь олон нийтэд нээлттэй байна. Тэр мэдүүлгээр тухайн шийдвэрийг шалгаж, бас түүнээс сургамж авч болно. Энэ бол териин ой санамж юм. “Сайн нь ч миний багш, муу нь ч миний багш” гэдэг шиг тухайн мэдүүлгийн хуудас Монголын териин шийдвэр гаргагчдын “багш” болж үлдэнэ.

Энэ хэлбэрийг бид ашиглаад эхэлчихсэн байгаа. Шуугчдийг дахин томилоходо бөглөсөн мэдүүлэг, шийдвэрийн чанарыг шалгаж байгаа. Харин суулийн үед Дээд Шүүх л чих халууцуулах боллоо. Авлигын хэргүүдээс их менгэ, төлбөртэй хэсгүүдийг нь голдуу хүчингүй болгоод байх юм. Хэдийгээр хараат бус ч гэсэн Дээд Шүүхийн шийдвэр Монголын түүхэнд сургамж болж үлдэж байгааг санах хэрэгтэй.

Шүүх авлигчдыг шийтгэж ч байна, өршөөж ч байна. Байдал өөрчлөгдөж байгаа ч авлигатай хийх тэмцэлд, бид эргэлт гаргах хэрэгтэй байна. “Эх нь хээр алаг бол унага нь шийр алаг” гарсаар л байх нь. Одоо эхтэй нь оролдох цаг ирж байна. Төрөө авлигажсан бүтцээс нь салгаж байж л Монгол Улс авлигаас салах нь. Иймээс Монголд териин шинэтгэл, ухаалаг төр хэрэгтэй.

Үндсэн санаа

ХУУЛЬ

Монголын Хөгжлийн Хүрээлэнгийн тухай

- ❖ МХХ-гийн бие даасан байдал болон судлаачдад тавих шалгуур, үйл ажиллагааны баталгааг хуульчлах,
- ❖ Стратегийн судалгааны төв, Үндэсний хөгжлийн хүрээлэнгийн бүтцэд суурilan байгуулах,

Хүрээлэнгийн зорилго нь:

- ❖ Улс орны урт хугацааны хөгжлийн талаарх судалгаа хийх, дүгнэлт гаргах ,
- ❖ Шийдвэр гаргагчдад бодлогын зөвлөгөө өгөх шийдвэрийн хэрэгжилт, үр дүнд үнэлгээ хийх,

Манай шийдвэр гаргагчдын хамгийн том дутагдал бол, өглөө аль хөл дээрээ боссон, сэтгэл хөдлөл, санаанд нь юу орсноос төрийн шийдвэрт нөлөөлж байна.

*“Төрийн шийдвэрт хамгийн дутагдаж байгаа зүйл бол судалгаа.
Судалгаагүй учраас төрийн шийдвэр тогтвортгүй, өгөөжгүй, муу үр дагавар
ихтэй байна”*

Үндсэн санаа

ХУУЛЬ

Төрийн албаны тухай

Одоо ухаалаг төрд ухаалаг албат хэрэгтэй болж ирнэ.

- ❖ Төрийн албананд ажиллагсдыг зөвхөн “чадахуйн зарчим”-д тулгуурлан сонгож томилох.
(оршин суугч)
- ❖ Төрийн албананд шинээр томилгоо хийхийг хязгаарлах.
- ❖ Шалгуурт тэнцэхгүй бол төрөөс явах.
 - Төрийн алба бол хүнд суртал бойжуулах цэцэрлэг биш
 - Төрийн алба бол асрамжийн газар биш
- ❖ Үр дүн, иргэдийн сэтгэл ханамжид суурилан урамшуулах.
- ❖ Төрд зөвхөн шилдэг нь, шударга нь, чадвартай нь ажиллах.
- Төрийн нийт албан хаагчдын тоо - 161.612 байна, төрийн өмчит ААН-д одоогоор 47.653 хүн ажиллаж байна.

“Ухаалаг төрд ухаалаг албат хэрэгтэй”

Үндсэн санаа

ХУУЛЬ

Төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэр, түүний бүртгэл, хяналтын тухай

- ❖ Шийдвэр тушаал гаргах эрхийг журамлах, хязгаарлах, хуульчлах,
- ❖ Нэгдсэн бүртгэлд оруулах, нээлттэй болгох,
- ❖ Тодорхой болгох: Албажих хугацаа, хариуцлагын тогтолцоо,
- Ухаалаг төрийн орчинд ингэж дураараа авирлах боломжгүй.
Тэнд төр нээлттэй, оролцоотой, хяналттай болно.

“Иргэндээ нээлттэй, иргэний оролцоотой, иргэний хяналттай төр л хариуцлагатай төр байж чаддаг”

ХУУЛЬ

Засгийн газар, төрийн захиргааны байгууллагын бүтцийн тухай

- ❖ Бүтцийг ухаалаг төрийн зарчимд нийцүүлж, үр ашигтай, цомхон, чадварлаг болгоно,
- ❖ Албан тушаалын давхардлыг арилгана, (УИХ, ЗГ, ИТХ)
- ❖ 10 жилээс доошгүй хугацаанд тогтвортой мөрдөнө,
- ❖ УИХ-ын гишүүний гуравны хоёрын саналаар өөрчлөлт оруулж болно,
- 1911 онд 5 яам, 1998 онд 9 яам, 2013 онд 16 яам.
- Төрийн зарим зохицуулалт шууд- автомат байх ёстой. (цаг хугацаатай, хязгаартай)
- Төр бол –олон талаараа онгоцтой адил.
 - Онгоцонд илүү ачаа байж болохгүй
 - Нисэх багийн үүрэг тодорхой- хуульчлагдсан , журамлагдсан, зөрчиж болохгүй, аюулгүй байх ёстой. Цаг хугацаандаа нисэж буух ёстой. 30 хүнд 1 үйлчлэгч гэх мэт.
 - Хянах самбар, бүх эд анги ажиллаж байх ёстой.
 - Нислэгийн хугацаа нь дуусвал нэг бол сольдог, засдаг.

Зургаа: Яаралтай хийх ажил АСУУЛГА

Нэг. Хэрэгтэй юу?

- ❖ Энэ яам, агентлаг, газар, хэлтэс, алба, хэсэг..?
- ❖ Энэ дарга, албан тушаалтан, зөвлөх, референт, мэргэжилтэн, шинжээч?
- ❖ Энэ байшин, машин, эд хөрөнгө, үйлчилгээ, зардал...?

Хоёр. Ёстой юу?

- ❖ Энэ ажлыг заавал төр хийх ёстой юу?

Гурав. Яагаад?

- ❖ Энэ ажлыг яагаад бусдаар хийлгэж, гэрээгээр гүйцэтгүүлж, шижлуулж болохгүй гэж? (мэргэжлийн байгууллага, олон нийт, ААН, орон нутаг, иргэд)
- Төрийн байгууллага, албан тушаалтан бүхэн энэ асуултгыг хий. Зарим нь бид байх ёстой, хуультай гэж хэлнэ. Хуулийт өөрчилье, шинэчилье, хүчингүй болгой.
- Лиценз, зөвшөөрлийг яаж алга болгож, шилжүүлж байгаа билээ. Яг түүн шиг.
- Хамгийн гол нь энэ ажлыг төр өөрөөсөө эхлэх хэрэгтэй. Төрд нэг дутагдал амь бөхтэй оршсоор байгаа. Хас гэхээр өөрөөсөө бусдыг хасах гээд байдаг. Дундаж дарга өнөөдөр 3 сая төгрөгний зарлагатай байна. Унаа, утас, шуудан, цалин, өрөөнийх нь цахилгаан дулааны төлбөр гээд. 1 дарга хасагдахад л 150 хүүхдэд хүүхдийн мөнгө олгож болж байна. Нэг агентлаг, яам хасагдвал юу хэмнэдэх нь ойлгомжтой.
- Та бүхэн харж байгаа байх Төрийг засахыг бид бэрхшээл биш боломж гэж харах хэрэгтэй. Бизнес гэж харах хэрэгтэй. Эдийн засгаа өстгөх, орлогоо нэмэгдүүлэх боломж гэж хар. Судлаачид, бизнесийнхэн, програм хангамж, иргэдэд урьд өмнө байгаагүй боломж гарч ирж байна. Иргэд, ААН-үүд одоо “Даргаа би ширээ нийлүүльье, контор засья, гэрээ хийе” гээд гүйлдээд эхэлнэ.

**“Төрийг хардаг хуучин сэтгэлгээнээсээ сал.
Шинэчлэлийн хамгийн хэцүү нь шинэ санааг
хэрэгжүүлэхэд бус хуучнаасаа салахад байдаг”**

Яаралтай хийх ажил

УЛСЫН ИХ ХУРАЛ

- ❖ Парламентын нээлттэй сонсгол, хянан шалгах, хариуцлага тооцох тогтолцоог иж бүрэн бүрдүүлж, хэрэгжүүлэх,
- ❖ УИХ, Ерөнхийлөгч, ЗГ-аас томилогддог албан тушаалтны бүрэн эрхийг түдгэлзүүлэх, зогсоох, чөлөөлөх, огцруулах (Impeachment) зэрэг хариуцлагын тогтолцоог ажиллуулах,
- ❖ Алдагдалтай төсөв батлахгүй байх, Төсвийн тогтвортой байдлын хуулийг тууштай мөрдөж, төсвийн сахилгыг чангатгах
 - **Төсвийг бай гэж үзвэл УИХ 10-ыг л онодог байх ёстой. Биелэлтээс хараад 7-д ч тусахгүй байна.**
- ❖ Татвар төсөвтэй холбоотой хууль санаачлах эрхийг зөвхөн Засгийн газарт өгөх
- ❖ Төрийн бараа үйлчилгээний болон захиргааны зардлыг царцаах,
- ❖ Засгийн газрын бонд, зээл, түүний хуваарилалт, зарцуулалт төлөлтийг зохицуулсан хууль батлах,
 - **ЧБонд. ХБанк гээд анхаарах юм бий. Мөнгөө зарахаас өмнө хуулиа гарга гэсэн, гаргаагүй л байна. (ЧБонд 4 жилийн дараа төлнө. ХБанк найдваргүй зээлийн үүр болох вий)**
- ❖ Төв банкинд тавих хяналтыг сайжруулах, алт, валютын нөөцийн зохистой харьцааг барих, нэмэгдүүлэх арга хэмжээ авах.
- ❖ Төрийн шинэтгэл, эдийн засгийн өсөлтийг дэмжих дэд хороо байгуулж ажиллуулах,
- ❖ Олон улсын болон хөрөнгө оруулалтын батлагдсан гэрээтэй холбоотой асуудлыг зөвхөн Засгийн газрын санал, санаачилгаар хөнддөг байх
- ❖ Төрийн болон улс төрийн албан тушаалтан хөрөнгө оруулалтын гэрээний хэлэлцээ хийхийг хуулиар хориглох.

“Төсвийг бай гэж үзвэл Улсын Их Хурал 10-т онодог байх ёстой”

Яаралтай хийх ажил

ЗАСГИЙН ГАЗАР

- ❖ Эрчим хүчээр өөрийгөө хангах (Нэмэлт үйлвэрлэл, найдвартай хангалт, экспортлох боломж)
- ❖ Төмөр замын бүтээн байгуулалт (Шинэ, дамжин өнгөрөх, шинэчлэл)
- ❖ Шатахуунаар өөрийгөө хангах (Олон эх үүсвэр, урт хугацааны гэрээ, дотоодын нөөцөд тулгуурласан үйлдвэрлэл)
- ❖ Агаарын тээврийг хөгжүүлэх (Хаб байгуулах, жижиг онгочны үйлчилгээ нэвтрүүлэх)
- ❖ Уул уурхайн бүтээгдэхүүнээс бусад экспортыг 30 хувьд хүргэх (97:3-70:30)
- ❖ Экспорт нэмэх, импорт орлох үйлдвэрлэлийг дэмжих (Уул уурхай, мал аж ахуй, газар тариалан, шинэ технологид суурилсан)
 - ЗГ хөрөнгө оруулалтад онцгой ач холбогдол өг. Залхуу хүний ажилд бүү дурла. Засаг зээлэхээр хуваарилалтаа дураараа, хяналтгүй хийж байна. Дараа нь ард түмэн л төлнө.
 - Манай засагт 2 юм илт буруу байна = (давхар дээлтэй, зээлэнд дуртай)
- ❖ Оюутолгой, Тавантолгой тойрсон асуудлыг шийдвэрлэх (Шуурхай, Харилцан ашигтай, нээлттэй)
- ❖ Үндэсний мэргэжлийн зөвлөх баг бүрдүүлэх. Үндэсний төслийн сан бий болгох
- ❖ Бизнесийн дарамт, сүүдрийн эдийн засгийг арилгах, есөлтийг дэмжсэн татварын шинэчлэл хийх
 - Төр хууль стандарт сахиулах ёстой. Мэргэжлийн хяналтынхан уг нь стандарт сахиулагчид .
 - Энд ч төр хэрэггүй л байгаа юм. Ерөөл архины стандартыг Хараа архи нь л илүү сахиулж байгаа юм. Иймээс энэ үүргийг бизнест өг. Төр хариуцлагаа тооц.
- ❖ Улсын хөрөнгө оруулалтын зэрэглэлийг өсгөх, хөрөнгийн зах зээлийг идэвхжүүлэх, баялгийн болон итгэмжит сангийн тогтолцоог бүрдүүлэх
 - Sovereign = Улсын, Trust = Итгэмжит. Улс гэдгийг – ард түмэн, Төр гэдгийг хууль гэж ойлго.
- ❖ Олон улсын нийтлэг стандарт, өндөр технологийн шаардлагыг нэвтрүүлж тууштай мөрдөх (Япон, Герман, Евро стандарт, технологи)
- ❖ Бүс нутгийн интеграцид ивэдхтэй оролцох, хөрш орнуудтай харилцах харилцаанд онцгой анхаарах
 - Эдийн засаг, мөнгө гэдэг бол бодлогийн ч, бодлогогүй ч үр дагавартай байдаг. Сайн ч бай муу ч бай мөр үлдээдэг. Үүнийг мартаж болохгүй.

“Засгийн газар хөрөнгө оруулалтад онцгой ач холбогдол өг. Залхуу хүний ажилд бүү дурла”

53

Яаралтай хийх ажил

Бусад

❖ **Хүний хөгжлийг гол болгох**

(оловсрол, эрүүл мэнд, халамж, даатгалын тогтолцоонд эрс шинэтгэл хийх)

❖ **Нийслэл, орон нутгийн хөгжлийн шинэ төлөвлөлтийг дэмжих**

❖ **Тогтвортой, өсөлт бүхий, ногоон хөгжлийн бодлогыг бүх салбарт хэрэгжүүлэх**

❖ **Газар, газрын харилцаа, өмчлөл, эргэлтийн асуудлыг шийдвэрлэх...**

“Хүн бүр хүүхдээ боловсролтой, эрүүл, зөв хүн болгохыг л хүсдэг.
Үүнд л төр үйлчлэх ёстой”

Яаралтай хийх ажил

Бизнес

❖ Төр, гэр бүлийн өмчлөлөөс олон нийтийн өмчлөлд шилжих. **Ингэснээр:**

- Иргэд баялаг бүтээгч, хамгаалагч болно.
- Компанийн засаглал сайжирч ил тод болно.
- Нийгмийн хариуцлага нэмэгдэнэ.

❖ Дотоодын хөрөнгийн зах зээлд идэвхтэй оролцох, хөрөнгө босгоход анхаарах

Хэвлэл мэдээлэл

❖ Олон нийтийн хэлэлцүүлэг өрнүүлэх. (төрийг хэрхэн шинэчлэх, эдийн засгийн өсөлтийг яаж нэмэгдүүлэх)
Ингэх нь:

- Монголын ард түмэнд хэрэгтэй,
- Монголын сайн сайханд хэрэгтэй
- Монголын ирээдүйд хэрэгтэй

Яаралтай хийх ажил

Орон нутаг

- ❖ Хөгжлийн асуудлаар хэлэлцүүлэг хийх
- ❖ Хөгжлийн зорилгоо тодорхойлж, тууштай мөрдөх

Яаралтай хийх ажил

Ерөнхийлөгч

- ❖ **Бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах:**
(Хуулийн засаглал, төрийн шинэчлэл, аюулгүй байдал)
- ❖ **Үндсэн хуульд орсон 7 өөрчлөлт.**

Төгсгөл

Өнөөдөр бид Монголын хөгжлийн гарц болох эдийн засгийн өсөлтийг яаж хангах, төрийн шинэчлэлийг яаж хийх талаар яришилаа.

Ингээд “Монголын Хөгжлийн Клуб” байгуулагдаж байгаа юм. Энэ клубт орох чөлөөтэй.

Монголын хөгжилд хувь нэмэр оруулж чадах хүн бүрт энэ клубын хаалга нээлттэй.